

**“ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэх үед Улсын Их Хурлын даргаас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хянан шалгах түр хороо байгуулах шаардлага, үндэслэлийг тодорхой зааж, төслийн холбогдох заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Байнгын хороонд буцаасан билээ.

Төсөл санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн үндэслэлийг хуульд нийцүүлэн тусгасныг албан бичгээр Байнгын хороонд ирүүлсэн.


Байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэлийг тусгасан саналыг хэлэлцэн дэмжиж, төсөлд саналыг тусган Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**П.АНУЖИН**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот**Хянан шалгах түр хороо байгуулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг хэсэг, **Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа, эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг шалгах шаардлагыг** тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудал”-аар байхаар тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах журам шийдвэр, түүний өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй байгаа асуудал;

2/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дахь эмийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, хяналт чанарын баталгаажуулалтын нөхцөл байдал;

3/зах зээлд дээр худалдаалагдаж буй байгаа зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан, нөхцөлийн талаар;

4/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дахь эмийн хүртээмж, тулгамдаж буй байгаа асуудал;

5/Монгол Улсад эмийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, эехүн хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох саналыг танилцуулах. Улсын Их Хуралд танилцуулсугай.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Өлөнхын бүлгийг **Олонхыг төлөөлөн:**

Д.Батлут Улсын Их Хурлын гишүүн

Б.Жаргалмаа Улсын Их Хурлын гишүүн  
М.Оюунчимэг Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн  
Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийн бүлгийг **Цөөнхийг төлөөлөн:**

Б.Бейсен Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Туваан Улсын Их Хурлын гишүүн

4. Улсын Их Хурлаас хугацааг сунгаснаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь энэ тогтоол баталсан өдрөөс хойш зургаан сарын дотор хяналт тусгай шалгалт явуулж тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулсугай.

5. Энэ тогтоолыг 2023 оны ... дугаар сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг